



## ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Барилгын Политехник Коллеж (БПК)-оос үүсэх хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, ангиллын дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлүүлэх, нийтийн эдэлбэр газрыг цэвэрлэх үйл ажиллагааг эрхлэхэд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Хог хаягдлын ангилал, нэр томъёоны тайлбар

- 2.1. "Хог хаягдал" гэж өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материалыг;
- 2.2. "Хог хаягдал цуглуулах эрх бүхий байгууллага" гэж хог хаягдал цуглуулах, тээвэрлэх зөвшөөрөлтэй, мэргэжлийн байгууллагыг;
- 2.3. "Эх үүсвэр дээр ангилах" гэдэг нь хог хаягдлыг үүсгэгч этгээд дахин ашиглах боломжтой болон бусад хог хаягдал, ахуйн аюултай хог хаягдал, барилгын хог хаягдал, эмнэлгийн хог хаягдал гэж энэхүү журамд заасны дагуу ангилан хаяхыг;
- 2.4. "Хог хаягдал цуглуулах" гэж хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор эх үүсвэрээс төвлөрүүлэхийг;
- 2.5. "Энгийн хог хаягдал" гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг;
- 2.6. "Аюултай хог хаягдал" гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг;
- 2.7. "Барилгын хог хаягдал" гэж барилгын суурь бэлтгэх, барилга барих, засварлах, буулгах болон авто зам барих, засварлахад үүсэх хог хаягдал, явган хүний зам талбай, ногоон байгууламжийн тохижилт, инженерийн шугам сүлжээ тавих, засварлах, солих үед үүсэх хог хаягдал болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэлээс гарах хог хаягдлыг хэлнэ.
- 2.8. **Эмнэлгийн хог хаягдалд:** Эрүүлийг хамгаалах үйл ажиллагааны явцад үүсэх хэрэглэгдсэн тариур, тариурын зүү, дуслын систем, хэрэгсэл, бохирдсон боолт, биеийн хэсэг, оношлогооны дээж, цус, химийн бодис, эм, эмнэлгийн багаж хэрэгсэл, радио идэвхит материалыг багтаана.

### Гурав. Баримтлах зарчим, ерөнхий шаардлага

- 3.1. Хог хаягдал үүсгэхгүй байх,
- 3.2. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах боломжийг бүрдүүлэх, эрэлхийлэх
- 3.3. Шинэ санаа, санаачлага гаргах, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх
- 3.4. Хог хаягдлыг ангилан ялгах, сөрөг нөлөөллийг бууруулахад багш, ажилтан, сурагцагчдын оролцоог хангах, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх,
- 3.5. Энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлүүлэх, дахин боловсруулах, устгуулах үйл ажиллагааг мэргэжлийн аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ хийж, гүйцэтгүүлнэ.

- 3.6. Гэрээ байгуулсан эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, журам энэ чиглэлээр батлагдан гарсан Монгол Улсын стандартыг мөрдөн ажиллана.
- 3.7. Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагааг явуулахдаа Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэнэ.

#### **Дөрөв. Энгийн хог хаягдал цэвэрлэх**

- 4.1. Нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах.
- 4.1.1. Дүүргийн засаг даргын захирамжаар нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулахад идэвхитэй оролцох,
- 4.1.2. Орчныхоо 50 метр талбайн хог хаягдал, цас мөсийг тогтмол цэвэрлэж байх,
- 4.1.3. Нийтийн эдэлбэр газар, талбайн их цэвэрлэгээг хуваарийн дагуу гүйцэтгэх,
- 4.2. Нийтийн цэвэрлэгээнд тавигдах шаардлага
- 4.2.1. Цэвэрлэсэн хог хаягдлыг ил задгай овоолон орхих, шатаахгүй байх;
- 4.2.2. Нийтийн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг ялган ангилж тусгайлсан уутанд хийж зориулалтын хогийн саванд цуглуулах,
- 4.2.3. Хөдөлмөрийн, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааг ханган цэвэрлэгээнд оролцож байгаа багш, ажилтныг амны хаалт, бээлий, болон холбогдох багаж хэрэгсэлээр ханган оролцуулах,
- 4.2.4. Хог хаягдал тээвэрлэхдээ зориулалтын машин техник ашиглах

#### **Тав. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах**

- 5.1. Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр дараах байдлаар ангилна.
- а. Дахин боловсруулах боломжтой хог хаягдал;
- б. Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал;
- в. Хүнсний органик хог хаягдал;
- 5.2. Хог хаягдлын төрлийг дараах өнгөөр илэрхийлнэ.
- а. Хуванцар, гялгар уут – Ногоон;
- б. Хөнгөн цагаан лааз, металл хаягдал – Улбар шар;
- в. Цаас – Цэнхэр;
- г. Шил – Цагаан;
- д. Хүнсний органик хаягдал – Бор;
- е. Бусад хог хаягдал – Хар;
- ж. Ахуйн аюултай хог хаягдал – Шар.
- 5.3. Энгийн хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав дараах шаардлагыг хангасан байна.
- 5.1.1. Ангилан ялгах хог хаягдлын төрлөөр хогийн савыг өнгөөр ялгасан, эсвэл ангилах, ялгах зориулалтын тэмдэг, тэмдэглэгээтэй байна.
- 5.1.2. Дотор хогийн сав 10-40, гадна 80-150 литрийн багтаамжтай байна.
- 5.1.3. Цоорч гэмтээгүй, салхиар тархахгүй, шингэн нэвчихгүй, угааж цэвэрлэхэд хялбар, тагтай, хуванцар, металл материалаар хийгдсэн.
- 5.1.4. Хог хаягдал цуглуулах сав байршуулах талбайн хөрсийг тэгшлэн нягтаршуулсан, цементлэсэн, зориулалтын хавтан дэвсгэр дэвссэн байна.
- 5.1.5. Хог хаягдлыг цуглуулах сав нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахааргүй газар, салхины доод талд, тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зай талбайтай байна.

- 5.4. Дахин боловсруулах боломжтой хог хаягдалд дараах хог хаягдлыг оруулна.
- 5.4.1. Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савалгаа/
  - 5.4.2. Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав/
  - 5.4.3. Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйлс
  - 5.4.4. Шил /хүнсний болон ундааны төрөл бүрийн шилэн сав, шилэн эдлэл/
  - 5.4.5. Лааз
  - 5.4.6. Мод, модон эдлэлийн хаягдал
  - 5.4.7. Хувцас, даавуун эдлэл
  - 5.4.8. Гялгар уут, хуванцар сав баглаа боодол
  - 5.4.9. Өвс, мод
- 5.5. Хүнсний хог хаягдалд дараах хог хаягдлыг оруулна.
- 5.5.1. Хоолны үлдэгдэл
  - 5.5.2. Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл
  - 5.5.3. Хэрэглэсэн хүнсний тос
  - 5.5.4. Яс
- 5.6. Бусад хог хаягдалд дараах хог хаягдал орно.
- 5.6.1. Хэт бохирдсон дахин ашиглагдах боломжгүй хог хаягдал,
  - 5.6.2. Барилгын болон туслаарлах материалаас гарсан дахин ашиглах боомжгүй хог хаягдал,
  - 5.6.3. Боловсруулсан дахин ашиглах боломжгүй бохир хөрс, шороо, чулуу, элс, хайрга
  - 5.6.4. Дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилалд ороогүй бусад зөвшөөрөгдсөн хог хаягдал
- 5.7. Ахуйн аюултай хог хаягдалд дараах хог хаягдлыг хамруулна.
- 5.7.1. Будаг, уусгагч бодис
  - 5.7.2. Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал (ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй)
  - 5.7.3. Хортон шавьж, мэрэгчдийг устгах хор
  - 5.7.4. Мөнгөн ус агуулсан хаягдал (термометр, мөнгөн ус ашиглагдсан унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, энэ төрлийн гэрэлтүүлгийн хэрэгсэл)
  - 5.7.5. Электрон барааны хаягдал (РС, телевизор, гар утас)
  - 5.7.6. Аэрозол буюу шүршигч савтай бүтээгдэхүүний хаягдал (пропан цилиндр)
  - 5.7.7. Түлэгч, идэмхий бодисууд (цэвэрлэгээний бодис)
  - 5.7.8. Хөргөгч бодис агуулсан гэр ахуйн бараа
  - 5.7.9. Зарим тусгай батерей (литиум, никель кадмум, электрон цагны зай)
  - 5.7.10. Дарь
  - 5.7.11. Радио идэвхит хаягдал (утаа мэдрэгч)

### **Зургаа. Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх**

- 6.1. Захиргаа, аж ахуй алба нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагатай гэрээ хийнэ.
- 6.2. Гэрээ байгуулсан эрх бүхий иргэн, байгууллага хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлт, устгалыг холбогдох стандартад нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.

- 6.3. Хог хаягдлыг гэрээний дагуу тогтсон хугацаанд, мөн дуудлагаар ачуулж, тээвэрлүүлнэ.
- 6.4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэхдээ хүрээлэн буй орчин, хөрсийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авна.
- 6.5.

#### **Долоо. Ахуйн хог хаягдлыг устгах**

- 7.1. Дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг цуглуулж, тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлж хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэнэ.
- 7.2. Эмнэлэгийн тусгай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ариутгаж халдваргүйжүүлэн зориулалтын уут саванд хийж мэргэжлийн байгууллагад дуудлагаар ачуулж тусгай байгууламжид хаяна.
- 7.3. Барилгын хог хаягдалыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж, хуваарийн дагуу ачуулж хогийн цэгт тогтоосон талбайд хаяна.
- 7.4. Ахуйн аюултай хог хаягдлыг зориулалтын тусгай ангиллын хогийн цэгт хаяж, дарж булна.

#### **Найм. Урамшуулал**

- 8.1. Хог хаягдлыг анхан шатанд ангилан ялгаж хэвшсэн, хог хаягдлыг дахин ашиглах шинэ санал санаачилгыг гаргасан, мөн хорёрдогч түүхий эдийг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулахад бусдад үлгэр дуурайл болсон багш, ажилтан, албан хаагчдыг урамшуулж, олон нийтэд сурталчилах, бүх талаар дэмжиж ажиллах,
- 8.2. Дээрхи дэмжлэг, урамшууллын арга хэмжээг Ногоон хорооны хүсэлт, тодорхойлолтыг үндэслэн Захиргаа, аж ахуй алба зохион байгуулна.

#### **Ес. Хориглох зүйлс**

- 9.1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгалгүй хаях,
- 9.2. Ангилсан болон бусад хог хаягдлыг зориулалтын хадгалах саванд байх тохиолдолд шатаах, гал гаргах, ухаж тараах
- 9.3. Ангилан ялгасан хог хаягдлыг цуглуулан тээвэрлэх эрх бүхий иргэн, байгууллагаас өөр этгээд цуглуулах, тээвэрлэх болон ямарваа нэгэн үйл ажиллагаа явуулах
- 9.4. Хог хаягдлыг нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, далан, шуудуунд ил задгай хаях
- 9.5. Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг цуглуулах зорилгоор хог хаягдлыг хүлээн авах цэгийг тусгайлан тогтоосон тохиолдолд хогоо зориулалтын бус газар, ил задгай хаяхыг хориглоно.

#### **Арав. Хүлээх хариуцлага**

- 10.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдийг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж холбогдох арга хэмжээг авна.
- 10.2. Энэхүү журмын биелэлтэд Дотоод чанарын баталгаажилт хариуцсан ажилтан хяналт тавина.

-----oOo-----